



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/88/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 81

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ж.БЯМБАСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан, хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\bichighep\2022A4\root

006020134

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:\bichighereg\2022\A4\foot

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>178,853,227.06</b>	<b>74,548,665.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	714,250.00	32,888,850.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	714,250.00	32,888,850.00
3351	Байгууллагаас авах авлага	714,250.00	714,250.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	32,174,600.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	176,624,927.06	41,659,815.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	13,694,000.00	1,148,900.00
35130	Эм боох материал	1,723,150.00	1,148,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	126,171,127.27	20,110,915.00
35410	Бичиг хэргийн материал	3,849,714.00	155,600.00
35420	Аж ахуйн материал	51,538,996.27	19,955,315.00
35600	Мал амьтад	28,710,000.00	20,400,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,698,417,371.58</b>	<b>1,597,094,124.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,698,417,371.58	1,597,094,124.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,619,493,371.85	1,518,512,624.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,417,385,038.10	4,417,385,038.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,010,140,998.85)	(3,116,578,718.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,300,000.00	15,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,300,000.00)	(15,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	262,524,653.75	286,105,366.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(217,586,686.72)	(237,400,910.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	206,347,469.23	216,444,197.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(135,690,537.76)	(153,195,378.64)
39209	Зам, гүүрийн байгууламж	16,782,800.00	26,282,800.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,413,317.92)	(12,292,041.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	595,600.00	595,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(595,600.00)	(595,600.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	59,000,000.00	59,000,000.00
39217	Ном	32,284,952.02	32,762,271.35
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	78,923,999.73	78,581,500.03
39301	Програм хангамж	1,550,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(180,000.27)	(522,499.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	77,554,000.00	77,554,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,877,270,598.64</b>	<b>1,671,642,789.61</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,877,270,598.64</b>	<b>1,671,642,789.61</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,877,270,598.64	1,671,642,789.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	616,216,186.21	616,216,186.21
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	616,216,186.21	616,216,186.21
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(411,690,527.96)	(617,318,336.99)
51210	Өмнөх үеийн үр дүн	(411,690,527.96)	(411,690,527.96)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(205,627,809.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,672,744,940.39	1,672,744,940.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,877,270,598.64</b>	<b>1,671,642,789.61</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

**Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,364,720,506.50</b>	<b>1,583,459,756.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,269,488,506.50</b>	<b>16,931,460.48</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,125,206.50	16,931,460.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,125,206.50	16,931,460.48
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,981,496.50	16,931,460.48
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>95,232,000.00</b>	<b>1,566,528,296.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	1,247,378,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	1,247,378,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	730,000.00	44,627,273.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	730,000.00	43,727,273.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,502,000.00	274,522,823.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,502,000.00	274,522,823.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,498,414,019.20</b>	<b>1,784,538,815.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,498,414,019.20</b>	<b>1,784,538,815.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,399,515,933.20	1,707,087,946.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	983,803,433.00	981,975,414.00
210101	Үндсэн цалин	584,024,166.00	582,894,449.00
210102	Нэмэгдэл	313,212,802.00	307,688,092.00
210104	Урамшуулал	86,566,465.00	91,392,873.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	123,100,627.00	124,102,769.00
210201	Тэтгэврийн даатгал	83,478,585.00	85,958,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,082,580.00	9,575,928.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,871,376.00	7,717,712.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,969,827.00	1,893,014.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,698,259.00	18,957,266.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	90,460,324.00	290,266,848.54
210301	Гэрэл, цахилгаан	6,079,490.00	7,520,136.00
210302	Түлш, халаалт	81,653,834.00	280,090,513.54
210303	Цэвэр, бохир ус	2,727,000.00	2,656,199.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,472,818.00	64,906,764.42
210401	Бичиг хэрэг	502,450.00	1,316,743.00
210402	Тээвэр, шатахуун	1,849,168.00	1,661,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,000.00	662,500.00
210404	Ном, хэвлэл	-	462,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,707,900.00	2,465,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,980,300.00	58,338,461.42
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,333,620.00	47,149,106.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	438,450.00	375,323.47
210502	Хоол, хүнс	23,679,920.00	28,374,368.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,215,250.00	18,399,415.16
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,302,192.00	15,751,916.72
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	371,250.00
210604	Урсгал засвар	3,302,192.00	15,380,666.72
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	800,000.00	414,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	414,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,133,000.00	5,562,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	809,000.00	5,562,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	163,109,919.20	176,958,427.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,359,813.00	10,484,022.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,155,920.00	21,496,397.15
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	157,594,186.20	144,978,007.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	98,898,086.00	77,450,869.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	18,327,070.00	26,629,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,287,270.00	24,029,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,039,800.00	2,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	80,571,016.00	50,821,269.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,571,016.00	50,821,269.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(133,693,512.70)</b>	<b>(201,079,059.03)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	7,100,000.00	6,680,000.00
145003	Хөрөнгө оруулалтын олз	7,100,000.00	6,680,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	9,559,109.11	11,600,000.00
225003	Хөрөнгө оруулалтын гарз	4,240,000.00	4,040,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,055,000.00	7,560,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(2,459,109.11)	(4,920,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(136,152,621.81)</b>	<b>(205,999,059.03)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

#### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,216,186.21	1,672,744,940.39	(275,537,906.15)		2,013,423,220.45
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>616,216,186.21</b>	<b>1,672,744,940.39</b>	<b>(275,537,906.15)</b>	-	2,013,423,220.45
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(136,152,621.81)		(136,152,621.81)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>616,216,186.21</b>	<b>1,672,744,940.39</b>	<b>(411,690,527.96)</b>	-	1,877,270,598.64
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>616,216,186.21</b>	<b>1,672,744,940.39</b>	<b>(411,690,527.96)</b>	-	1,877,270,598.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>616,216,186.21</b>	<b>1,672,744,940.39</b>	<b>(411,690,527.96)</b>	-	1,877,270,598.64
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(205,627,809.03)		(205,627,809.03)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>616,216,186.21</b>	<b>1,672,744,940.39</b>	<b>(617,318,336.99)</b>	-	1,671,642,789.61

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,377,487,113.00</b>	<b>1,569,417,598.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,282,255,113.00</b>	<b>2,889,302.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	26,891,813.00	2,889,302.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,891,813.00	2,889,302.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,962,020.00	2,889,302.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>95,232,000.00</b>	<b>1,566,528,296.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	1,247,378,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	1,247,378,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	730,000.00	44,627,273.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	730,000.00	43,727,273.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,502,000.00	274,522,823.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,502,000.00	274,522,823.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,361,428,520.00</b>	<b>1,540,964,298.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,361,428,520.00</b>	<b>1,540,964,298.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,262,703,884.00</b>	<b>1,466,034,089.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	983,803,433.00	981,975,414.00
210101	Үндсэн цалин	585,549,019.00	582,894,449.00
210102	Нэмэгдэл	311,687,949.00	307,688,092.00
210104	Урамшуулал	86,566,465.00	91,392,873.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	123,100,627.00	124,102,769.00
210201	Тэтгэврийн даатгал	83,478,585.00	85,958,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,895,649.00	9,575,928.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,058,307.00	7,717,712.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,969,827.00	1,893,014.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,698,259.00	18,957,266.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,071,444.00	272,523,723.00
210301	Гэрэл, цахилгаан	6,079,490.00	7,112,616.00

**Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	78,992,454.00	263,039,888.00
210303	Цэвэр, бохир ус	2,999,500.00	2,371,219.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,354,050.00</b>	<b>28,059,833.00</b>
210401	Бичиг хэрэг	430,850.00	875,373.00
210402	Тээвэр, шатахуун	1,849,100.00	1,661,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,000.00	662,500.00
210404	Ном, хэвлэл	-	206,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	1,553,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,441,100.00	23,100,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,922,860.00</b>	<b>31,484,880.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,000.00	506,700.00
210502	Хоол, хүнс	25,704,660.00	28,236,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,860,200.00	2,741,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,155,500.00</b>	<b>14,999,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,000,000.00
210604	Урсгал засвар	2,155,500.00	1,999,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>800,000.00</b>	<b>414,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	800,000.00	414,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,180,800.00</b>	<b>1,659,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	856,800.00	1,659,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,315,170.00</b>	<b>10,814,470.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,670,170.00	10,814,470.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,724,636.00</b>	<b>74,930,209.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,153,620.00</b>	<b>24,108,940.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,553,820.00	23,308,940.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,599,800.00	800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>80,571,016.00</b>	<b>50,821,269.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,571,016.00	50,821,269.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>16,058,593.00</b>	<b>28,453,300.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4,128,800.00</b>	<b>28,453,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,128,800.00</b>	<b>28,453,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,128,800.00</b>	<b>28,453,300.00</b>
222001	Тоног төхөөрөмж	2,390,000.00	16,279,800.00
223001	Бусад хөрөнгө	1,738,800.00	12,173,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(4,128,800.00)</b>	<b>(28,453,300.00)</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	0.00	1523669600.00	1473969056.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	1523669600.00	1465986756.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	1495653200.00	1441877816.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	0.00	1005132500.00	981975414.00
210101	Үндсэн цалин	0.00	0.00	603331300.00	582894449.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00	326353700.00	307688092.00
210104	Урамшуулал	0.00	0.00	75447500.00	91392873.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	0.00	134892800.00	124102769.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	94687500.00	85958849.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	9891400.00	9575928.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	8201000.00	7717712.00

**Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	2010300.00	1893014.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	20102600.00	18957266.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	0.00	274291400.00	272523723.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	8110000.00	7112616.00
210302	Тулш, халаалт	0.00	0.00	263141400.00	263039888.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	3040000.00	2371219.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	0.00	7594500.00	6303560.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	425200.00	538100.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	1663300.00	1661830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	663,600.00	662,500.00
210404	Ном, хэвлэл	-	-	340,400.00	206,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	1,276,600.00	1,163,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	3,225,400.00	2,071,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	-	41,540,700.00	31,484,880.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	506,700.00	506,700.00
210502	Хоол, хүнс	-	-	38,291,600.00	28,236,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	2,742,400.00	741,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	-	15,000,000.00	4,999,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	13,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	-	2,000,000.00	999,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-	425,200.00	414,000.00
210702	Дотоод албан томилолт	-	-	425,200.00	414,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	1,660,200.00	1,659,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	1,660,200.00	1,659,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	15,115,900.00	4,414,470.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	15,115,900.00	4,414,470.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	28,016,400.00	24,108,940.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	28,016,400.00	24,108,940.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-	27,216,400.00	23,308,940.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	800,000.00	800,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	<b>7,982,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-	-	7,982,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	7,849,800.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	132,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	-	1,524,583,745.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	1,247,378,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	1,247,378,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	274,522,823.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	-	274,522,823.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	-	2,682,722.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	2,682,722.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛГИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>44,627,273.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>24,156,273.00</b>

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	24,156,273.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	21,756,273.00
210401	Бичиг хэрэг	-	337,273.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	390,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	21,029,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	20,471,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	20,471,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	8,430,000.00
223001	Бусад хөрөнгө	-	12,041,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	44,627,273.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	44,627,273.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,727,273.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хишиг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Эцэг эх, олон нийт багш нар Зөв хүүхэд” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Багш
  1. Ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлэх
  2. Сурагчдын идэвхтэй үйлийг дэмжин арга зүйг эзэмшиж, хөгжүүлэх
  3. Монгол бичгийн унших, бичих чадвараа ахиулах.
- ✓ Сургалцагч
  1. Ахлах ангийн суралцагчид мэргэжлийн чиг баримжаанд чиглэсэн хичээл сонголтыг хийж, үе шаттай сорилтуудыг өгч, амжилтаа ахиулан суралцах.
  2. Дунд ангийн суралцагчид бие даан сурах арга барилд суралцаж, хоггүй, ногоон орчин бүрдүүлэхэд хичээнгүйлэн оролцох.
  3. Бага ангийн суралцагчид уншиж бичих, тооцоолох чадвараа ахиулж, мэндлэх, хүндлэх, туслах зээг найрсаг харилцаанд суралцах.
- ✓ Ажилтан, ажилчид
  1. Төрийн албаны ёс зүй, зарчмыг эрхэмлэн, сураглагчдын сурах, амьдрах ая таатай орчныг бүрдүүлэн, тусалж дэмжин ажиллах

2. Цахим хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэн, туршиж сайжруулахад багшийг дэмжих гэсэн зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээний баг бүрэлдэхүүнийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй өөрчлөн баталсан байна. Дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1.507.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 15.08 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	714.2	32888.8	-32174.6
Бараа материал	178138.9	41659.8	136479.2
Үндсэн хөрөнгө	5089324.5	5132979.3	-43654.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1877270.6</b>	<b>1671642.8</b>	<b>205627.8</b>
<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Хуримтлагдсан үр дүн	-411690.5	1055426.6	643736.07
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1877270.6</b>	<b>1671642.8</b>	<b>205627.8</b>

**Авлага:** Өмнөх оны авлага буюу оны эхний үлдэгдэл 0.7 сая төгрөг, тайлант онд 35.06 сая төгрөгийн хувь хүнээс авах болон бусад зардлын тооцооллын авлага үүсэж 2.8 сая төгрөгөөр барагдуулж тайлант онд эцсийн үлдэгдэл 32.8 сая төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 178.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 41.6 сая төгрөг болж өмнөх оноос 136.5 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 94.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 71.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, бусад бараа материалаас шилжүүлж авсан 14.8 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 8.4 сая төгрөгийн бараа материал тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 5089.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5132.9 сая төгрөг болж өмнөх оноос 43.6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 28.4, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 15.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Өглөгийн дансанд оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлага зэргийг тодруулж тайлагнасан болно.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд улсын төсвөөс 1.224.4, орон нутгийн төсвөөс 276.3 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 он улсын төсвөөс 1.247.4, нэмэлт дансаар 44.6, орон нутгийн төсвөөс 274.5, үндсэн үйл ажиллагааны орлого 2.9 сая төгрөг буюу нийт 1.569.3 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1.518.6 сая төгрөгийг зарцуулж 50.8 сая төгрөгийг төвлөрүүлж тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нэмэлт дансаар нийт 44.6 сая төгрөгийн санхүүжилт авснаас бичиг хэргийн зардалд 0.3, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн зардалд 0.4, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 21.03, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 2.4, тоног төхөөрөмжийн зардалд 8.4, бусад хөрөнгийн зардалд 12.04 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ковид буюу цар тахалтай холбогдуулан ариутгал цэвэрлэгээний бодис, материалын хэрэглээ шаардлага нэмэгдсэн бөгөөд зардал хүрэхгүй байгаа тул дотуур байрны хоолны

зардлаас 1.0 сая төгрөгийг нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал дээр мөн дээрх зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дээр 1.5 сая төгрөгийг тус тус хуваарийн өөрчлөлт хийлгэх хүсэлт дээд газартаа хүргүүлсэн байна.

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/05 дугаартай тушаалаар лабораторийн сургуулийн нэмэгдэл олгох тухайг БШУ-ны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн “Лаборатори сургуулийн нэмэгдлийн тухай” А/05 тушаалыг тус тус үндэслэн 68 багш ажилчдад 15, 30 хувийн нэмэгдэл тус тус олгожээ.

1-р багийн малчин Б.Ганзориг 0.7 сая төгрөгийн үнэ бүхий телевизор дүрслэх урлагийн багш Шаравнямд, 3-р багийн малчин Ж.Батбаатар 0.6 сая төгрөгийн өнгөт принтер нярав, нягтлан бодогч нарт, 2004 оны төгсөгчдийн хамт олноос 0.7 сая төгрөгийн телевизор дотуур байранд тус тус хандивласныг орлого авч тайлагнажээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 7 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор хандиваар олгосон үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг бүрэн тусгаж, зардал хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан мөн хичээл үйлдвэрлэлийн зардлаас 11.1 сая төгрөгийн notebook, зурагт, ухаалаг дэлгэц, тогтоогч хөл худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн нь Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хавсралтыг зөрчсөнг холбогдох хууль журмын дагуу албан шаардлага өгч ажилласан.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд 2021 онд бүрэн мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 3 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 91 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Ажилчдын илүү цагийн бүртгэл, нэгтгэлтэй холбоотой анхан шатны баримтын бүртгэлийг архивлаж үдээгүй, цэгцгүй учраас анхаарал татахуйц байна. Иймд цалин, илүү цагийн нэмэгдлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 21.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.3 сая төгрөгийн зөрчилд 1 залруулга хийж, 11.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажиллалаа.

##### **4.1 Санхүүгийн тайлантай холбоотой залруулсан алдаа**

*Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг буруу тооцож санхүүгийн тайланд зөрүү үүссэнг залрууллаа.*

##### **4.2 Төлбөрийн акт**

*Төлбөрийн акт тогтоогоогүй*

##### **4.3 Албан шаардлага**

*Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 11.1 сая төгрөгийн notebook, зурагт, ухаалаг дэлгэц, тогтоогч хөл худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн. Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг зөрчсөн байна.*

##### **Шийдвэрлэсэн нь:**

*Албан шаардлага хүргүүлэв.*

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Цалингийн зардалтай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

*Цалингийн зардлаас Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг бүлэг хооронд 3.1 сая төгрөгийг шилжүүлэн төлсөн.*

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

*Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын хавсралтад заасан заалтыг мөрдөж ажиллах.*

#### **2. Тогтмол зардалтай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

*Цэвэр бохир усны зардлын 6 гүйлгээний нэмээгдсэн өртгийн албан татварын баримт дутуу байна.*

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

*Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.*

#### **3. Шуудан холбооны зардалтай холбоотой асуудал**

##### **3.1. Илрүүлэлт:**

*Шуудан холбооны зардлыг Жи-мобайл ХХК-тай 1 жилийн гэрээ байгуулсан боловч 0.5 сая төгрөгөөр юнител, скайтелын нээж, дата авч гэрээгээ зөрчсөн, 0.2 сая төгрөгөөр жи-мобайлын нээж, дата авсан боловч НӨАТ байхгүй.*

##### **Өгсөн зөвлөмж:**

*Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.*

#### 4. Бага үнэтэй түргэн элэгдэх зардалтай холбоотой асуудал

##### 4.1. Илрүүлэлт:

Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас Хаан банкны хуучин тавилгаас 0.5 төгрөгөөр 2 ширээ, 3 тек, 1.1 сая төгрөгийн 2 зурагт зэрэг хөрөнгө бэлтгэсэн.

##### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" хавсралтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/сая/төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Хишиг-өндөр сумын ЕБС	6	21.6	1	5.3	0	0	1	11.1	4	5.2